

Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

2020 оны жилийн эцэс

Д/д	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2020 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
4.1. Судалгаа боловсруулалтын ажлын үр дүнд бий болсон шинэ мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн инновацийн үйл ажиллагааг хөгжүүлэх						
1	4.1.1. их сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, аж үйлдвэрийн хамтын ажиллагаанд түшиглэсэн инновацийг хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, шийдвэр, үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий үндэсний зөвлөл байгуулж ажиллуулах	2018 - 2021			2019 онд Инновацийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг батлуулсан. Уг хуулиар их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын дэргэдэх гарааны компани, гарааны бизнесийг дэмжих, олсон орлогоо захиран зарцуулах болон гарааны компани хувьцаа олон нийтэд санал болгох, инновацийн бүтээгдэхүүн үйлчилгээнээс ашиг хүртэх зохицуулалтыг тус тус тусгаж өгсөн. Мөн инновацийн судалгаа хөгжүүлэлтийн үр дүнд бий болсон бүтээгдэхүүн үйлчилгээг төрийн худалдан авалтаар дэмжих, гааль, татварын бодлогоор дэмжих, инновацийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, грант олгох, инновацийн тэргүүлэх чиглэлээр судалгаа хийх, төрөөс дэмжлэг үзүүлэх зэрэг эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлсэн.	100%

2	4.1.2. инновацийн үйл ажиллагааг дэмжих, гарааны бизнест хөрөнгө оруулалт хийхэд чиглэсэн тусгай зориулалтын хөрөнгө оруулалтын сан (Венч, Эндаумент сан гэх мэт)-г байгуулах, ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх	2018 - 2021		Хөрөнгө оруулалтын тухай хууль, Хамтын хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, холбогдох журмыг Санхүүгийн зохицуулах хорооноос батлуулж, уг хууль тогтоомж, дүрэм журмын дагуу тусгай зориулалтын сан байгуулах, ажиллах эрх зүйн орчин бүрдсэн байгаа. Харин БШУЯ-ны ИТГ-аас 2021 онд МУ-д байгуулагдан үйл ажиллагаа явуулж буй тусгай зориулалтын сангуудыг бүртгэх, үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт, өнөөгийн нөхцөл байдлыг судлах судалгааг зохион байгуулахаар төлөвлөлтөд тусган хэрэгжүүлж байна.	100%
3	4.1.3. их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд судалгаа боловсруулалтын ажил, дэвшилтэт болон шинэ технологи, бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, нэвтрүүлэх, нутагшуулах зорилгоор дотоод, гадаадын хандив, тусламж, хөрөнгө оруулалт авах, захиран зарцуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх	2018 - 2021		2019 онд Инновацийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг батлуулсан. Уг хуулиар их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын дэргэдэх гарааны компани, гарааны бизнесийг дэмжих, гадаадын хандив, тусламж, хөрөнгө оруулалт авах, олсон орлогоо захиран зарцуулах болон гарааны компани хувьцаа олон нийтэд санал болгох, инновацийн бүтээгдэхүүн үйлчилгээнээс ашиг хүртэх зохицуулалтыг тус тус тусгаж өгсөн.	90%

4	4.1.4. оюуны өмчийн үнэлгээ хийх, ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх	2018 - 2021		Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах, оюуны өмчийг эзэмших, ашиглах, хамгаалах, үнэлгээ хийхтэй холбоотой зохицуулат бүхий хуулийн төслийг ОӨГ-аас чиг үүргийн хүрээнд боловсруулахад санал авч тусган батлуулсан. Уг хууль 2020 оны 12 дугаар сарын 01-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж, мөрдөж байна. Мөн Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн Зохиогчийн эрх, түүнд хамаарах эрхийн тухай болон Барааны тэмдэгт газарзүйн заалтын тухай хуулийн төсөлд холбогдох саналыг хүргүүлж тусгасан. Уг хуулиуд батлагдан хэрэгжиж эхлээд байна. Мөн Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайд болон Оюуны өмчийн газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/12 тоот хамтарсан тушаалаар “2019-2020 онд шинжлэх ухаан, технологийн салбарын оюуны өмчийн үнэлэмжийг нэмэгдүүлэх төлөвлөгөө”-г батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
5	4.1.5. шинэ мэдлэг, технологи, оюуны бүтээлийг зах зээлд нэвтрүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	2018 - 2021		Инновацийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1.9 дахь хэсгийг тус тус үндэслэн “Инновацийн төсөл бүртгэх журам батлах тухай” Засгийн газрын тогтоолын болон журмын төслийг боловсруулан Засгийн газрын 2019 оны 11 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 392 дугаар тогтоолоор батлуулсан. Энэхүү журмаар инновацийн төслийг хүлээн авах, үнэлгээ өгч, дүгнэлт гаргах, мэдээллийн санд бүртгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар тусгасан. Инновацийн төслийг бүртгэлжүүлэн, үйл ажиллагааг дэмжсэнээр оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулж, нэмүү өртөг шингээсэн, оюуны багтаамж, технологийн агууламж бүхий инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд тодорхой ахиц дэвшил гарна гэж дүгнэж байна.	90%
6	4.1.6. гарааны бизнес эрхлэгчид, энтерпренёр, шинийг санаачлагч, оюуны өмчийн мэргэшсэн үнэлгээчдийг бэлтгэх, давтан сургах, чадавхжуулахад	2018 - 2021		“Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, 162 дугаар тогтоолоор батлуулсан. МУ-ын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн ивээл дор зохион байгуулсан Шинжлэх ухааны ажилтны улсын анхдугаар их хуралд “Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийн хөгжил” салбар хуралдаан зохион байгуулж түүнээс гарсан зөвлөмжийг үндэслэн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан. “Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 онд батлуулж,	100%

	чиглэсэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх				хэрэгжилтийг зохион байгуулж байна.	
4.2. Аж үйлдвэрийн тэргүүлэх салбарын өрсөлдөх чадвар, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, нутагшуулах, гарааны компанийг дэмжих замаар аж ахуйн нэгжийн инновацийг хөгжүүлэх						
7	4.2.1. өндөр технологи шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэсэн бизнесийг хууль эрх зүй, татвар, хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжих	2018 - 2021			Жил бүр инновацийн бараа бүтээгдэхүүн үйлчилгээний зориулалттай гарааны компанийн гадаадаас оруулж ирж буй тоног төхөөрөмжийн жагсаалтыг Засгийн газраар батлуулж гааль, татварын хөнгөлөлт үзүүлж байна. Инновацийн тухай хуулийн 16 зүйлд заасны дагуу технологи дамжуулах төв, эсхүл хамтын оффисд гишүүнчлэлээр бүртгүүлсэн гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг төрөөс татварын бодлогоор дэмжих журмын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Засгийн газрын 2018 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан “Үндэсний инновацийн шагнал олгох журам”-ын 5.2 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 192 дугаар тогтоолын дагуу “Шилдэг инновацийн бүтээгдэхүүн”-ээр шалгарсан Баргилтех ХХК-ийн “Эко барьцалдуулагч” бүтээгдэхүүн, “Үйлчилгээний салбарын шилдэг инноваци”-аар шалгарсан Ворлд плас дижитал ХХК-ийн “Ворлд плас аппликэйшн” бүтээгдэхүүнүүдэд Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн Үндэсний инновацийн шагналыг гардуулж, тус бүр 30 сая төгрөгийн мөнгөн урамшууллыг олгосон.	100%
8	4.2.2. инновацийн тэргүүлэх чиглэлийг тогтоож, түүний хүрээнд шинэ үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгон, гадаадын дэвшилтэт технологи нэвтрүүлэн	2018 - 2021			МУЗГ-ын 2020 оны 03 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлж, 95 дугаар тогтоолоор “Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл”-ийг 5 технологи, 11 салбар чиглэлд үндсэн шинж чанар, технологийг тодорхойлж, батлуулсан. Ингэснээр инновацийн тэргүүлэх салбар чиглэлд хөрөнгө нөөцийг төвлөрүүлж, инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, чанар хүртээмжийг дээшлүүлж, судалгаа хөгжүүлэлтийн үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах боломж бүрдэж багяаа юм.	100%

	нутагшуулахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжих					
9	4.2.3. аж үйлдвэрийн салбарт инновацийн экосистемийг бүрдүүлж, экспортын брэнд бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлэх	2018 - 2021			2018 онд “Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого, 2019 онд “Инновацийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль”, 2020 онд “Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр”-ийг тус тус батлуулж, инновацийн экосистемийг бүрдүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрэн бүрдүүлсэн.-ийг тус тус батлуулж, инновацийн экосистемийг бүрдүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрэн бүрдүүлсэн. Үүний зэрэгцээ “МУЗГ-ын 2020 оны 03 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлж, 95 дугаар тогтоолоор “Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл”-ийг 5 технологи, 11 салбар чиглэлд үндсэн шинж чанар, технологийг тодорхойлж, батлуулсан. Ингэснээр инновацийн тэргүүлэх салбар чиглэлд хөрөнгө нөөцийг төвлөрүүлж, инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, чанар хүртээмжийг дээшлүүлж, судалгаа хөгжүүлэлтийн үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах боломж бүрдэж байгаа юм. Жил бүр тогтмол Инновацийн долоо хоногийн арга хэмжээний үеэр “Инновацийн үзэсгэлэн”-г зохион байгуулж уг үзэсгэлэнд инноваци нэвтрүүлж буй байгууллагуудын төлөөлөл болох 60 гаруй байгууллагын 400 гаруй бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд танилцуулж, худалдан авах, инновацийн бүтээгдэхүүн үйлчилгээг эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг бүрдүүлж байна. Мөн БНХАУ-ын ӨМӨЗО-д зохион байгуулагдсан “3 дахь удаагийн Монгол-Хятадын ЭКСПО”-ийн үеэр Монгол, Хятадын шинжлэх ухаан, технологи, инновацийн хамтын ажиллагааны түвшинг ахиулах, хоёр орны хамтарсан төслийн үйл ажиллагааг дэмжих, хоёр орны голлох үйлдвэрлэл болон ирээдүйтэй салбарын технологийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол-Хятадын технологи дамжуулалт, инновацийн хамтын ажиллагааны хоёрдугаар форумыг хамтран зохион байгуулж, Монголоос төр, хувийн хэвшлийн эрдэм шинжилгээний хүрээлэн төвүүд, их дээд сургуулийн дэргэдэх гарааны бизнес эрхлэгчид бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулах, сурталчлах, худалдах үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан.	100%
10	4.2.4. инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг төрийн	2018 - 2021			Төрөөс инновацийн талаар баримтлах бодлогын төслийн 4.4 дэх зорилтын “4.4.6-д: Инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй аж ахуйн нэгж орлогынхоо хоёр хувиас доошгүй хөрөнгийг судалгаа боловсруулалтын ажилд зарцуулсан	100%

худалдан авалтаар дэмжих			<p>тохиолдолд төр худалдан авалтаар дэмжинэ.”, 4.5 дах зорилтын “4.5.3-т: Инновацийн стратегийн тэргүүлэх чиглэлээр үйлдвэрлэл эрхэлж буй үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын судалгаа, боловсруулалт, технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг төрөөс санхүү, хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжинэ.” гэсэн заалтыг тусгасан байгаа. Мөн Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Эрүүл мэндийн салбарт хийгдсэн инноваци шингэсэн бүтээгдэхүүний жагсаалт балах тухай” А/66 дугаар тушаалаар 16 нэр төрлийн бүтээгдэхүүнийг баталж, улсын хэмжээний үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг өгч, хэрэгжилтийг хангаж байна. Үүнээс гадна Шинжлэх ухаан, технологийн сан, Байгаль орчны яам, Онцгой байдлын ерөнхий газруудтай хамтран ажиллаж, эрдэмтдийн тухайн салбарт бүтээсэн инновацийн бүтээгдэхүүнийг төрийн худалдан авалтаар дэмжин хамтран ажиллаж байна. Т/бал: Байгаль орчны яам 400 сая төгрөг, Онцгой байдлын ерөнхий газарт “Малын долооц нийлүүлэх” зэрэг ажлуудыг хамтран хэрэгжүүлэхээр зохион байгуулсан. Монгол эрдэмтэн судлаачид, гарааны компаниудын инновацийн бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор цахим худалдааны Scientific E-SHOP платформыг Шинжлэх ухаан, технологийн сан дээр хөгжүүлэн ажиллаж, цахим худалдааг тогтмол зохион байгуулах, судалгаа хөгжүүлэлтийн үр дүнг сурталчлах ажил тогтмолжсон.</p>	
11 4.2.5. инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, өндөр технологийн үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт хийсэн, нутагшуулсан аж ахуйн нэгжийг татвар, зээлийн бодлогоор дэмжих	2018 - 2021		<p>Засгийн газрын 2018 оны 234 дүгээр тогтоолоор "Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд явуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалт"-ыг батлуулсан. Батлагдсан жагсаалтад зааснаар: Инновацийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай нийт 7 төрлийн үйлдвэрийн 113 нэр төрлийн тоног төхөөрөмжийг татвараас чөлөөлөхөөр тогтоолд тусган баталсан. Үүнд:Сарлагийн хөөврөн бүтээгдэхүүний үйлдвэрийн 2, Малын эм, эм бэлдмэлийн үйлдвэрийн 16, Эм, эмийн бэлдмэлийн үйлдвэрийн 11, Төмсний үр үржүүлгийн үйлдвэрийн 18, Ургамал хамгааллын бэлдмэл, бүтээгдэхүүний үйлдвэрийн 9, Тэжээлийн үйлдвэрийн 10, Газар тариалан, бордооны үйлдвэрийн 47 болно. Мөн Засгийн газрын 2019 оны 448 дугаар тогтоолоор “Инновацийн төслөөр дотоод, гадаадын зах зээлд шинэ бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай шинэ бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай дотоодод үйлдвэрлэдэггүй түүхий эд, урвалж бодисын жагсаалт”-ыг батлуулсан: Гоо сайхны бүтээгдэхүүний</p>	100%

				<p>үйлдвэрлэлийн 60, Лабораторийн оношлуур үйлдвэрлэлийн 93, Биотехнологи, микробиологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн 93, Байгалийн эрдэст бэлдмэлийн үйлдвэрлэлийн 33, Эм, эм бэлдмэлийн үйлдвэрлэлийн 34, Малын эм, эм бэлдмэлийн 7, Шимт тэжээл, туршилт үйлдвэрлэлийн 12 урвалж бодис буюу нийт 7 төрлийн үйлдвэрлэлийн 273 нэр төрлийн түүхий эд, эм, урвалж бодисыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөхөөр шийдвэрлэсэн</p>	
12	<p>4.2.7. гарааны компани, инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагаа, дэд бүтэц, хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн сан бий болгох</p>	<p>2018 - 2021</p>		<p>Монгол эрдэмтэн судлаачид, гарааны компаниудын инновацийн бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор цахим худалдааны Scientific E-SHOP платформыг Шинжлэх ухаан, технологийн сан дээр хөгжүүлэн ажиллаж, цахим худалдааг тогтмол зохион байгуулах, судалгаа хөгжүүлэлтийн үр дүнг сурталчлах ажил тогтмолжсон. Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн салбар, инновацийн үйл ажиллагаатай холбоотой бодлогын баримт бичиг, статистик тоо мэдээллийг салбарын бодлого боловсруулагчдад зориулсан GoSpin нэгдсэн платформд тогтмол оруулж байна. Зарим бодлогын баримт бичгийн англи хэлээрх албан бус орчуулгын хамт оруулж байна. БШУ-ны сайдын тушаалаар төсвийн хөрөнгөөр хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлын ШУТСанд хадгалагдаж буй тайлангуудыг олон нийтэд нээлттэй болголоо.</p>	<p>100%</p>
<p>4.3. дэвшилтэт технологийг төрийн үйлчилгээнд нэвтрүүлэх замаар нийгмийн инновацийг хөгжүүлэх</p>					
13	<p>4.3.1. тоон технологийг ашиглан төрийн мэдээлэл, үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэхэд чиглэсэн инновацийн үйл ажиллагааг төр, иргэн, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын</p>	<p>2018 - 2021</p>		<p>Улаанбаатар хотын Хонхорын станцыг тоон технологид шилжүүлэхээр урьдчилсан ТЭЗҮ боловсруулсан байна. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг "Алсын хараа-2050"-д Олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоог хөгжүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр боловсруулан тусгуулсан. Үүнд: Тоон технологи ашиглан мэдээлэл, үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэхэд чиглэсэн инновацын үйл ажиллагааг төр, иргэн, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх</p>	<p>70%</p>

	түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх					
14	4.3.2. дэвшилтэт технологийг төрийн үйлчилгээнд нэвтрүүлэх замаар нийгмийн инновацийг хөгжүүлэхэд чиглэсэн инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлсэн болон хөрөнгө оруулалт хийсэн аж ахуйн нэгжийг хөрөнгө оруулалт, татварын бодлогоор дэмжих	2018 - 2021			Засгийн газрын 2018 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан “Үндэсний инновацийн шагнал олгох журам”-ын 5.2 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 192 дугаар тогтоолын дагуу “Шилдэг инновацийн бүтээгдэхүүн”-ээр шалгарсан Баргилтех ХХК-ийн “Эко барьцалдуулагч” бүтээгдэхүүн, “Үйлчилгээний салбарын шилдэг инноваци”-аар шалгарсан Ворлд плас дижитал ХХК-ийн “Ворлд плас аппликэйшн” бүтээгдэхүүнүүдэд Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн Үндэсний инновацийн шагналыг гардуулж, тус бүр 30 сая төгрөгийн мөнгөн урамшууллыг олгосон.	90%
15	4.3.3. аж ахуйн нэгж, олон нийтэд инноваци, энтерпренёршипийн боловсрол олгох, инновацийн соёлыг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, шинжлэх ухаан, технологи, танин мэдэхүйн төрөл бүрийн контент	2018 - 2021			Олон нийтэд инноваци, энтерпренёршипийн боловсрол олгох, инновацийн соёлыг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн Шинжлэх ухаан, танин мэдэхүйн төрөл бүрийн контент хийх, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны хамрах хүрээ, хэрэгжүүлэх арга хэмжээний судалгаа, төлөвлөлтийг хийж, хэрэгжилтийг зохион байгуулж байна.	50%

	бүтээх ажлыг дэмжих					
16	4.3.6. зайн сургалтаар орон нутгийн иргэдэд инновацийн талаар мэдлэг олгох, инновацийн соёлыг түгээн дэлгэрүүлэх ажлыг үе шаттай, тогтмол зохион байгуулах	2018 - 2021			Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч болон Аймаг, нийслэлийн засаг даргын хооронд 2021 онд Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээнд Инновацийн хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, инновацийн тэргүүлэх чиглэл, холбогдох дүрэм журмын хэрэгжилтийг хангахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж Зайн болон танхимын сургалтаар дамжуулан орон нутгийн иргэдэд инновацийн талаар мэдлэг олгох, инновацийн соёлыг түгээн дэлгэрүүлэх ажлыг үе шаттай, тогтмол зохион байгуулахаар тусгуулсан.	50%
4.4. Орчин үеийн аж үйлдвэр, өндөр технологийн салбарт байгальд ээлтэй, эдийн засгийн үр ашигтай технологийг хөгжүүлэх						
17	4.4.1. төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан инновацийн үйлдвэрлэл технологийн дэд бүтэц (технологийн инкубатор, туршилтын үйлдвэр, технологи дамжуулах төв, бизнес-инкубатор, гарааны компани, шинжлэх ухааны болон өндөр технологийн парк, тоон технологийн зангилаа төв, хамтын оффисууд гэх мэт)-ийг	2018 - 2021			2020 оны статистик мэдээгээр 31 хүрээлэн, 5 төв, их, дээд сургуулийн харьяа 21 Эрдэм шинжилгээний байгууллага, нэгж үйл ажиллагаа явуулж байна. “Монгол Улсад инкубаторын үйл ажиллагааг хэрэгжүүлэх болон мэдээллийн серверийн бүтээн байгуулалт” болон “Технологи дамжуулах төвийн платформыг байгуулах” төслүүдийг БНХАУ-ын Шинжлэх ухаан, технологийн яамтай хамтран хэрэгжүүлж байна. Цаашид дараах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх шаардлагатай байна: • 2020-2024 онд 10 технологийн инкубатор, технологи дамжуулах төв байгуулахад 5,000 сая ₮, 3 салбар дундын нэгдсэн, төрөлжсөн лаборатори байгуулахад 30,000 сая ₮ төгрөгийн хөрөнгө оруулалт, санхүүжилт шийдвэрлэх; •Технологийн инкубатор, технологи дамжуулах төв 10, салбар дундын нээлттэй лаборатори 2-оос доошгүйг байгуулах ; •Ховд аймаг, Дорнод аймаг, Дархан хотын давуу тал, онцлогт тулгуурлан шинжлэх ухаан, технологи, инновацийн төвүүдийг байгуулах; •Шинжлэх ухааны паркийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх. Азийн хөгжлийн банкны 30 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр 2021-2024 онуудад хэрэгжих “Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх” төслийн хүрээнд шинжлэх ухааны байгууллагуудын бүтээл, судалгааны үр дүнг их, дээд сургуулийн сургалтад ашигладаг механизмыг бүрдүүлж, сургалт, судалгаа, инновацийн төвүүдийг их, дээд сургуулиудад байгуулахаар ажиллаж байна.	70%

	байгуулах, түүнд хөрөнгө оруулалт хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх					
18	4.4.2. төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан орчин үеийн аж үйлдвэр, технологийн дэвшлийн тэргүүлэх чиглэлээр бизнес эрхлэх, гарааны компани байгуулах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хөрөнгө оруулалт хийх ажлыг бодлогоор дэмжиж, тогтворжуулах	2018 - 2021			Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 99 дүгээр тогтоолоор батлагдсан “Инновацийн үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам”-ын дагуу инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд гаргах зорилгоор инновацийн үйл ажиллагаанд оролцогчид грант ажлыг зохион байгууллаа. 2020 оноос эхлэн хэрэгжүүлэх инновацийн төслийн сонгон шалгаруулалтыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлаж, http://www.project.edu.mn/) цахим хаягаар 27 төслийн санал бүртгэж хүлээн авсан. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/196 дугаар тушаалаар батлагдсан шинжээчийн багийн бүрэлдэхүүнээр инновацийн төсөлд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулсан. “Инновацийн үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам”-ын дагуу мэргэжлийн шинжээчдийн үнэлгээ дүгнэлтийг үндэслэн 10 инновацийн төсөлд грант олгохоор шинжээчдийн шийдвэрийг баталгаажуулсан.	100%